

“Эрдэнэс-Тавантолгой”ХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2018 оны
10 дугаар сарын 23 ны өдрийн 1/374
дугаар тушаалын 20 дугаар
хавсралт

КОМПАНИЙН АЖЛЫН БАЙРЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ҮЗЛЭГИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.“Эрдэнэс-Тавантолгой” хувьцаат компани (цаашид “ЭТТ” ХК гэх)-ийн Уурхайн ажлын байрын аюулгүйн ажиллагааг тодорхойлох, аюулыг эрсдлийн түвшингээр үнэлж осол, гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2.Энэхүү журам нь “ЭТТ” ХК-ийн Уурхайн бүсэд үйл ажиллагаа явуулж буй гэрээт болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч компани, тэдгээрийн ажилтанд хамааран үйлчилнэ.

1.1. Энэхүү журамд тусгагдаагүй асуудлыг холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, ажлын горим, заавраар шийдвэрлэнэ.

Хоёр. Ажлын байрын үзлэг

2.1.Ажилтан ажлын өөр байранд шилжин ажилласан тохиолдол бүрт шилжин ажиллаж буй ажлын байрны үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэнэ.

2.2.Ашиглалтын нэгжийн удирдах ажилтнууд уурхайн идэвхитэй бүсэд нэвтрэхдээ ээлжийн мастеруудын бичсэн “Ээлжийн тэмдэглэл”-ийг уншиж, зааварчилгаа авна.

2.3.Ээлжийн мастер¹ нь хариуцаж буй хэсгийнхээ ажлын байрны өдөр тутмын үзлэгийг хариуцан хийж гүйцэтгэнэ.

2.4.Ахлах ажилтан өөрийн хариуцаж буй хэсгийн ажлын байрны долоо хоног тутмын үзлэг шалгалтыг хариуцан гүйцэтгэнэ.

2.5.Хөдөлмөр, аюулгүйн байгууллага /цаашид ХАБ гэх/-ын ажилтан бүх ажлын байрны гэнэтийн шалгалтыг долоо хоногт нэгээс доошгүй удаа хийж гүйцэтгэнэ.

2.6.Нэгжүүдийн удирдлага нь ХАБ-ын болон Эрүүл ахуйн ажилтантай хамтран тухайн нэгжийн ажлын байрны үзлэг, шалгалтыг сард нэгээс доошгүй удаа хийнэ.

2.7.Үзлэг, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээг тусгай хуудсан дээр тэмдэглэн авч, шуурхай хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

2.8.Ээлжийн мастер нь ажил эхэлсэнээс хойш 1 цагийн дотор дахин үзлэг шалгалт хийж, уурхайн нөхцөл байдлыг бүрэн хянаж, үзлэг шалгалтыг ээлжийн турш хийнэ.

2.9.Ээлжийн мастер нь тухайн ээлжний ажилтанг эрсдэлд оруулахгүйн тулд уурхайн бүхий л хэсэг, талбарт үзлэг хийнэ.

2.10.Уулын ажил түр зогссон тохиолдолд тухайн ажлын байрыг хариуцсан ажилтнууд болон ээлжийн мастер ээлжиндээ нэгээс доошгүй удаа үзлэг шалгалт хийнэ.

2.11.Уурхайн хажуугийн тогтворжилт алдагдсан, хөрсний гулсалт бүхий бүсийн ойролцоо тоног төхөөрөмж ажиллах тохиолдолд ээлжийн мастер, ХАБ-ын ажилтан байнгын хяналт тавина.

Гурав. Ажлын талбай руу нэвтрэх

¹ Уулын болон Зам овоолгын мастер, Талбайн зохион байгуулагч зэрэг ойролцоо чиг үүрэг бүхий хүмүүс.

3.1.Эрүүл мэнд, байгаль орчин, эд хөрөнгөнд аюул учруулж болох хэмжээний эрсдэл үүссэн бүс рүү эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлтэйгээр тухайн ажилтныг нэвтрүүлнэ.

3.2.Уурхайн ажлын бүс рүү ороход дараах зарчмыг баримтлана.

3.2.1.Уурхайн ахлах ажилтан шалгалт хийж, аюулгүй гэж тогтоогоогүй л бол уурхайн ажилт явагдсан мөргөцөг болон уурхайн гүн рүү эсхүл өндөр хананы ирмэгээс 20 метрээс дотогш зайд нэвтрэхгүй байх;

3.2.2.Ажилтан уурхайн ахлах ажилтан эсхүл ээлжийн мастертай холбогдож зөвшөөрөл авсны үндсэн дээр уулын ажлыг эхлүүлэх;

3.2.3.Уурхайн идэвхитэй бүсэд засвар үйлчилгээ хийхээс өмнө үзлэг шалгалтыг ахлах механик хийж, тухайн хэсэгт нэвтрэх, засвар хийхэд аюулгүй гэдэг баталгааг гаргах;

3.2.4.Засвар үйлчилгээ эхлэхээс өмнө ахлах механик нь засвар үйлчилгээний ажил хийгдэх хэсэгт ажилчдын эрүүл мэнд болон аюулгүй байдалд нөлөөлөх хэмжээний аюул эрсдэл байхгүй гэдгийг баталгаажуулсан байх;

3.2.5.Эрсдлийн үнэлгээгээр тогтоогдсон орохыг хориглох шаардлагатай хэсгүүд (жишээ нь суваг шуудуу, ус зайлуулах суваг, гулгалттай хөрс эсхүл аюултай газар болон аюултай ажлын байр буюу хязгаарлагдмал орчинд гагнуур хийх зэрэг)-ийн аюул эрсдлийг “хүлээн зөвшөөрөгдөх” хэмжээнд хүртэл багасгахын тулд зохих журмын дагуу хаалт хашилт, тэмдэгжүүлэлт хийж, оролтыг хязгаарлан энэ тухайгаа ээлжийн мастер ажилчдад мэдээлдэг байх зэрэг болно.

3.3.Ажилтан ажил хийх зөвшөөрөл олгогдоогүй байхад хориглосон бүсэд нэвтрч үл болно.

Дөрөв. Үүрэг

4.1.Ажилтан бүр ажлаа эхлэхийн өмнө өөрийн ажлын байрандаа үзлэг хийж, илрүүлсэн аюулыг арилгах, үзлэгийн хуудас²т тэмдэглэнэ.

4.2.Тоног төхөөрөмжийн оператор нь тухайн техникийг ажиллуулахаас өмнө үзлэгийн маягтын дагуу заавал үзлэг хийж, бүх эвдрэл гэмтлийн талаар мэдээлэх, эвдрэлтэй, гэмтэлтэй техникийг ашиглахгүй байна.

4.3.Ээлжийн мастер нь уурхайн үйл ажиллагааны идэвхтэй бүсэд болон түүний эргэн тойронд өдөр тутмын үзлэг хийж, үзлэгийн хуудаст тэмдэглэх, илэрсэн аюулыг цаг алдалгүй арилгана.

4.4.Бүх мастерууд нь өөрийн хариуцсан ээлжийн ажил эхлэхийн өмнө бүх зам талбай, тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд хяналт тавьж шалгах бөгөөд зөрчил илэрсэн тохиолдолд уг зөрчил гэмтлийг арилгасны дараа ажлыг эхлүүлнэ.

4.5.Уурхайн Хөдөлмөрийн Аюулгүй Байдал (ХАБ)-ын ажилтан нь компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин (ХАБЭАБО)-ы бодлогын дагуу энэхүү журамд зааснаар өөрсдийн ажлын байрны үзлэгийг хийж илэрсэн зөрчлийг тэр даруй арилгах арга хэмжээ авна.

4.6.Ахлах ажилтан нь энэ журамд зааснаар ажлын байрны үзлэгийн журмыг мөрдүүлэх, мөрдөх үүргийг хүлээнэ. Ахлах ажилтан нь тухайн нэгжийнхээ ажилтан бүрээр ажлаа эхлэхээс өмнө ажлын байрны аюулгүй байдлыг шалгуулж, илэрсэн аюулыг арилгуулна.

4.7.Уурхайн бүх ажилчид уурхайн аюулгүй ажиллагааны зааварчилгааны нэг хэсэг болох ажлын байрны үзлэг шалгалтын шаардлагуудтай танилцана.

² Үзлэгийн хуудсыг тухайн хэлтэс нэгжийн удирдлага боловсруулан баталж хэрэглэж хэвшүүлэх үүрэгтэй.

4.8.Тоног төхөөрөмжийн оператор ганцаараа эсхүл тусгаарлагдсан орчинд ажиллах тохиолдолд цаг тутам радио холбоогоор ахлах ажилтантайгаа холбоо барьж нөхцөл байдлыг мэдээлнэ.

4.9.Уурхайн бүх ажилчид ажлын байрныхаа нөхцөл байдлыг ажил гүйцэтгэх явцдаа байнга хянаж ажиллана.

4.10.Нөхцөл байдал өөрчлөгдөх, шинээр аюул илрэх тохиолдолд эрсдлийн үнэлгээ дахин хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч ажиллана.

4.11.Хяналт шалгалтын байгууллага, орон нутгийн засаг захиргааны эрх бүхий байгууллага болон хууль, тогтоомжоор эрх олгосон бусад байгууллага, албан тушаалтнууд уурхайд шалгалт хийх үед ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.12.Ахлах ажилтан нь дор дурдсан үүрэгтэй.

4.12.1.Хариуцсан нэгжийн ажлын байрны үзлэг шалгалт хийгдэж буй эсэхийг баталгаажуулна.

4.12.2.Засч сайжруулах арга хэмжээний гүйцэтгэлийн явцыг хянана.

4.12.3.Өөрийн хариуцсан хэсгийн долоо хоног тутмын ажлын байрны үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэнэ.

4.12.4.Анхаарал татсан засч залруулах шаардлагатай арга хэмжээг шуурхай шийдвэрлэнэ.

4.13.Ээлжийн мастер нь дор дурдсан үүрэгтэй.

4.13.1.Уурхайд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн журмууд хангалттай хэрэгжиж байх, ажил бүр ААШ-нд бичигдсэний дагуу хийгддэг, эрсдэлд хяналт тогтоодог, шинээр аюул эрсдэл үүсэхгүй байх зэргийг хангаж ажиллана.

4.13.2.Энэхүү журамд тусгагдсаны дагуу үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэнэ.

4.13.3.Уурхайн ажилчдад ажлын байрны үзлэг хийх үед нь туслана.

4.14.4.Ажлын байрны үзлэгийн явцад илэрсэн доголдлыг залруулах арга хэмжээнд идэвхитэй биечлэн оролцоно.

4.14.5.Бүх ААШ³ нь компанийн стандартын дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавьж баталгаажуулна.

4.14.Уурхайн ажилчид дор дурдсан үүрэгтэй.

4.14.1.Уурхайн бүх ажилчид нь энэхүү журамд орсон ажлын байрны үзлэгийн шаардлагууд болон Монгол Улсын бусад хууль дүрмийг дагаж мөрдөнө.

4.14.2.Үзлэг шалгалтын явцад илэрсэн аливаа асуудлыг ахлах ажилтандаа яаралтай мэдээлж цаашдын арга хэмжээг авахуулна. Энэ асуудал нь бүрэн шийдэгдэх эсхүл эрсдэл хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл буурах хүртэл ажлаа эхлүүлэхгүй байна.

4.15.Зочид дор дурдсан үүрэгтэй.

4.15.1.Зочид нь уурхайдр айлчилж байх явцдаа анзаарсан аливаа аюултай нөхцөл байдлын талаар тэднийг дагуулан явж буй ажилтанд нэн даруй мэдэгдэнэ.

Тав. Залруулах арга хэмжээ, бусад үзлэг шалгал

³ ААШ – Ажлын Аюулын Шинжилгээ

5.1.Ажлын байрын аюулгүй ажиллааны доголдлыг холбогдох ахлах ажилтнуудад мэдээлж, гүйцэтгэсэн үзлэг шалгалтын төрлөөс шалтгаалан компанийн эсхүл уурхайн холбогдох маягт хуудсанд тэмдэглэж бүртгэнэ.

5.2.Ахлах ажилтан дор дурдсан зүйлсийг харгалзан үзсэний үндсэн дээр байнгын хяналт хийж байх үүргийг хүлээнэ.

5.2.2.Хийж гүйцэтгэсэн үзлэг шалгалтын тайлангийн дараалал ба тоо;

5.2.3.Бөглөсөн маягтын үнэн зөв байдал;

5.2.4.Хийж гүйцэтгэсэн болон хийхээр хүлээгдэж буй засч сайжруулах арга хэмжээний тоо;

5.2.5.Хэрэгжүүлсэн залруулах арга хэмжээний үр дүн

5.3.Уурхайд дараах үзлэг болон бусад төрлийн шаардлагатай шалгалтыг хийж гүйцэтгэнэ.

5.3.1.Засварын цехийн журмын дагуу хийгдэх машин механизм, тоног төхөөрөмжийн үзлэг шалгалтууд.

5.3.2.Өргөх төхөөрөмж, механизмын хуулиар тогтоосон үзлэг шалгалт.

5.3.3.Гал унтраах болон анхны тусламжийн тоног төхөөрөмжийн үзлэг шалгалт.

5.3.4.Өдөр тутам хийгддэг тойрох үзлэг, ажлын байрны ажиглалт зэрэг болно.

Зургаа. Бусад

6.1.Илэрсэн зөрчил, аюул болон залруулах арга хэмжээг нарийвчлан тусгасан албан ёсны бүх үзлэг шалгалтын үр дүнтэй уурхайн ажилчид хүссэн үедээ танилцаж болно.

6.2.Ээлжийн мастерын тайланг ээлж бүрийн үйл ажиллагааны тэмдэглэлтэй хавсаргаж ахлах ажилтанд хүлээлгэж өгнө.

6.3.Бүх үзлэг шалгалтын тайланг холбогдох хэлтэс, газарт хадгалагдана.

6.4.Энэ журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, "ЭТТ" ХК-ийн Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээнд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

6.5.Энэ журмын 1,2 дугаар хавсралтад заагдсан Аюултай бодис шалгах хуудас, Зөрчил арилгасан мэдээний хуудсыг ажилдаа тус тус мөрдлөг болгоно.

--- оОо ---

Энэ форм нь ажилчид болон ахлах ажилчдад аюултай бодистой холбоотой гарсан эрсдлүүдийг зохицуулахад нь туслана. Үүнийг ямар нэг АЮУЛТАЙ бодистой харьцан ажиллахаас өмнө бөглөх ёстой. Ерөнхийдөө ахлах ажилтан эсхүл талбай дээр байгаа ХАБ-ын ажилтан тухайн ажил эхлэхээс өмнө энэ хуудсыг бөглөсөн байна.

Энэ хуудсыг бөглөсний дараа хуулбарыг нь Аюултай Бодисын Бүртгэл болон ХАЛМ (Хор Аюулын Лавлах Мэдээлэл)-д хавсаргана.

Төсөл/Ажлын талбай:		Үнэлсэн огноо:		
Бодисын аюулыг үнэлсэн эсэх:				
Үнэлсэн хүн:				
		Чагтал		
БОДИС		ТИЙМ	ҮГҮЙ	Тайлбар
1	ХАЛМ-ийг шалгасан уу? Хэзээ?			
2	ХАЛМ нь хүчинтэй юу? (< 5 жилээс бага)			
3	ХАЛМ нь "Аюултай" гэж тэмдэглэгдсэн үү?			
4	Энэ бодистой ажиллахад тусгай нөхцөл шаардлагатай юу?			
5	Өөр хор багатай бодисоор орлуулж болох уу?			
Шаардлагатай НБХХ:				
ХЭРЭГЛЭГЧ		ТИЙМ	ҮГҮЙ	Тайлбар
6	Энэ бодисыг ашиглаж байгаа хүмүүст анхны тусламжын хэрэгсэл хангалттай бий юу?			
7	Астма г.м тухайн хүний эрсдлийг нэмэгдүүлэх эрүүл мэндийн хүчин зүйл байна уу?			
8	Тухайн ажилчин уг бодистой яаж ажиллахаа мэдэж байгаа юу? Сургагдсан уу? Хэзээ?			
9	Ажилчинд энэ бодисын ХАЛМ нь байна уу?			
10	Ажилтан нь бүх шаардлагатай НБХХ бий юу?			
11	Ажилтан нь НБХХ-ээ яаж хэрэглэхээ мэдэх үү?			
12	Ажилтан нь НБХХ-ээ яаж хадгалахаа мэдэх үү?			
АЖЛЫН ОРЧИН		ТИЙМ	ҮГҮЙ	Тайлбар
13	Энэ бодисыг тодорхой хугацаанд эсхүл хэдэн өдөр байнга эсхүл урт хугацаагаар хэрэглэж болох талаар урьдчилан тооцсон уу?			
14	Уг бодисыг хэрэглэж байх явцад нь тухайн хүнд үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор хэрэглэгчийг нь өөрчлөх боломжтой юу?			
15				

ЭРСДЛИЙН ХЯНАЛТ	
Дээрх улаан нүдэнд чагталвал эрсдлийг бууруулах шаардлагатай гэж үзээд дахин хянаж аюулыг арилгах арга хэмжээ авна.	
Бодис хэрэглэх зөвшөөрөл авсан хүний нэр:	
Гарын үсэг:	Огноо:

Хуваарилалт: Уг бодисыг ашиглах газар ETT-OHS-CP-15 журам, Аюултай бодисын бүртгэл, ХАЛМ болон ААШ-тэй хамт байна.

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШАЛГАХ ХУУДАС "АЮУЛТАЙ БОДИС"

Ахлах ажилтан:

Байрлал:

БҮХ “ҮГҮЙ” ХАРИУЛТЫГ ТАЙЛБАР/АРГА ХЭМЖЭЭ ХЭСЭГТ ТАЙЛБАРЛАЖ БИЧНЭ.

		ТИЙМ	ҮГҮЙ
1	Энэ бодисын ХАЛМ нь байна уу?		
2	ХАЛМ-д нь бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг нь нарийн тодорхой тусгасан байна уу?		
3	Энэ бодисыг хэрэглэх ажилчид нь яаж уг бодисыг аюулгүй хэрэглэх талаар сургагдсан уу?		
4	Шаардлагатай хадгалах зөвшөөрөл байгаа юу?		
5	Бүх аюултай бодисыг Аюултай Бодисын Бүртгэлд оруулсан уу?		
6	Анхны тусламж болон Асгаралтыг багтаасан Онцгой байдлын төлөвлөгөө байгаа юу?		

ТАЙЛБАР/АРГА ХЭМЖЭЭ:

Гарын үсэг:

Огноо:

ХАВСРАЛТ-2. ЕТТ-ОHS-CF15-A1-Зөрчил арилгасан мэдээний хуудас

АЖЛЫН БАЙРНЫ 2-Р ШАТНЫ ҮЗЛЭГЭЭР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН ДАГУУ АВСАН АРГА ХЭМЖЭЭ

1: (тэмдгийн өмнө хэлтсийн нэрийг бичнэ үү)

№	Байршил	Аюулын зэрэг	Илэрсэн зөрчил	Фото зураг (Өмнө)	Фото зураг (Дараа)	Авах арга хэмжээ	Авсан арга хэмжээ
1							
2							
3							
4							
5							
			Зөрчлийн тоо		Илэрсэн зөрчилд арга хэмжээ авсан эсэх (тоон үзүүлэлтээр)		
Хэлтэс нэгж, компани			Биелсэн	Биелээгүй	%	Биелээгүй тухай тайлбар	